



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 56

Номгон

“GIMEX” ХХК-д дэмжлэг үзүүлэх тухай

“Gimex” ХХК-иас ирүүлсэн хүсэлт, аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг дэвсгэрт анх удаа цагаан будаа тариалах тухай GIMEX ХХК-ний хүсэлтийг хүлээн авч дэмжиж, өргөн мэдүүлсэн аймгийн Засаг даргын санал санаачилгыг сайшаасугай.

2.Цагаан будаа тариалах, үйлдвэрлэх “Gimex” ХХК-ийг бодлого зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, цагаан будаа тариалалтын явцтай газар дээр нь танилцаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР